

**ЦАХИЛГААН ШАТАНД ЗАСВАР, ТЕХНИК ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

2023 оны -р сарын -ны өдөр

№

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас “.....” СӨХ /цаашид “ЗАХИАЛАГЧ” гэх/ түүнийг төлөөлж гүйцэтгэх захирал, нөгөө талаас “Улаанбаатар лифт” НӨҮГ /цаашид “АЖИЛ ГҮЙЦЭТГЭГЧ” гэх/ түүнийг төлөөлж дарга Д.Ган-Эрдэнэ /хамтад нь талууд гэх/ нар Монгол улсын Иргэний хууль, бусад хууль тогтоомж, Барилга хот байгуулалтын яамны сайдын 2008 оны 53 дугаар тушаал хавсралт №1 батлагдсан Лифтийг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм, бусад холбогдох дүрэм журмыг үндэслэл болгон дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Үндсэн нөхцөл

- 1.1 Ажил гүйцэтгэгч нь Захиалагч талын эзэмшлийн үйлдвэрлэсэн маркийн хүн зөөврийн, зогсоолтой, м/с хурдтай, кг даацтай ширхэг шатанд засвар, техник үйлчилгээний ажлыг “Лифт төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм” –ийн дагуу хийж гүйцэтгэх, захиалагч нь уг ажлын үр дүнг зохих журмын дагуу гүйцэтгэлээр хүлээн авч, төлбөрийг гэрээгээр тохиролцсоны дагуу төлнө.
- 1.2 Цахилгаан шатны байршил
 - 1.2.1 дүүрэг, дугаар хороо, хороолол байр

Хоёр. Ажлын хөлс

- 2.1 Цахилгаан шатын тоо: ширхэг
- 2.2 Нэг цахилгаан шатны техник үйлчилгээний хөлс сард-н төгрөг байна.
- 2.3 Нийт нэг цахилгаан шатны нэг сарын НӨАТ тооцсон техник үйлчилгээний төлбөр-н төгрөг байна.
- 2.4 Захиалагч нь засвар, техник үйлчилгээний төлбөрийг ажил гүйцэтгэснээс хойш 5 өдрийн дотор Нийслэлийн төрийн сан банкны 100200051073 тоот дансанд шилжүүлнэ.
- 2.5 Сар бүрийн ТҮ-ний төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд дараа сараас эхлэн хоног тутамд 0,5%-ийн алданги тооцно.
- 2.6 Лифт сэлбэг хэрэгсэлгүйн улмаас тодорхойгүй хугацаагаар зогсох тохиолдолд захиалагч тал гүйцэтгэгч талд төлбөрөөс чөлөөлүүлэх хүсэлтээ албан бичгээр мэдэгдэж, гүйцэтгэгч тал газрын зөвлөлийн хурлаар хэлэлцэж дээрх асуудлыг шийдвэрлэнэ.
- 2.7 Захиалагч тал нь төлбөрөө 3 сараас дээш хугацаанд төлөөгүй тохиолдолд лифтний гэмтлийн дуудлагад очихгүй, бөгөөд гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авна.

Гурав. Гэрээний хугацаа

- 3.1 Ажил гүйцэтгэх хугацааг хоёр тал харилцан тохиролцож тогтоов.
- 3.2 Ажил эхлэх хугацаа: оны ... дугаар сарын –ны өдрөөс эхэлнэ.
- 3.3 Гэрээ дуусах хугацаа: оны ... дугаар сарын –ны өдөр дуусна.
- 3.4 Энэ гэрээний хугацаа дуусгавар болоход талууд гэрээний 6-д заасны дагуу гэрээг дүгнэж акт үйлдэнэ.
- 3.5 Гэрээний хугацааг тодорхойлох, тоолохдоо Монгол Улсын Иргэний хуулийн 71-73-р зүйлд заасан журмыг баримтална.

Дөрөв. Захиалагчийн эрх, үүрэг

- 4.1 Цахилгаан шатны өдөр тутмын ажиллагааг хариуцаж эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд гүйцэтгэгчид даруй мэдэгдэн, засуулна.

- 4.2 Мэргэжлийн /үнэмлэх бүхий/ цахилгаан шатны лифтчинг ажиллуулж, тэдгээрийн аюулгүй ажиллагааг хангана.
- 4.3 Захиалагч талын эрх бүхий этгээд ажил гүйцэтгэгчийг ажлын явц байдал, түүний чанар, нарийвчлал, техникийн болон стандартын шаардлага, үр дүнд хяналт шаардлага тавих эрхтэй.
- 4.4 Машины өрөө, хонгил, бүхээгний гэрэлтүүлгийн бүрэн байдал, цахилгааны оруулгын төхөөрөмж хүртэлх тэжээлийн хэвийн байдал, бүхээг, машины өрөө, худгийн ариун цэврийн байдал, цахилгаан шатны эд ангийн харуул хамгаалалтыг хариуцаж, цахилгаан шатны оношлол, засвар үйлчилгээ хийх үед өөрийн төлөөлөгчөө заавал байлцуулна. Гэхдээ худгийн цэвэрлэгээг зөвхөн засварын механикийг байлцуулж, аюулгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх үед гүйцэтгэнэ. Машины өрөөний хувьд зөвхөн шал, хана, тааз, цонх, хаалгыг цэвэрлэнэ.
- 4.5 Цахилгаан шатны хэвийн ажиллахад шаардагдах сэлбэг материал, мөн техник, засвар үйлчилгээний үед шаардлагатай тос тослогооны материал, алчуур болон бусад шаардлагатай зүйлсийг гүйцэтгэгч талд авч өгөх.
- 4.6 Лифтийг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрмийн 5.5-д заасны дагуу машины өрөөнд лифттэй холбогдолгүй ямар нэг тоног төхөөрөмж, шугам сүлжээ байхыг хориглоно. Мөн цахилгаан тоног төхөөрөмжид гарсан галыг унтраах зориулалт бүхий Е серитэй галын хорыг байрлуулах шаардлагатай.
- 4.7 Лифтийг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрмийн 27.6-д заасны дагуу лифтийн бүхээгт цахилгаан шатны ашиглалтын үеийн аюулгүйн санамж, аваарын үед холбогдох утасны дугаар бүхий пайз байрлуулсан байна.
- 4.8 Машины өрөө тоос шороогүй, эд зүйлс хураагаагүй, анхааруулах, сануулах тэмдэг тэмдэглэгээнүүдийг байрлуулсан байна.
- 4.9 Захиалагч ажлын үр дүнг аливаа эвдрэл, гэмтэл дутагдал, доголдол илэрсэн тохиолдолд илэрснээс хойш ажлын нэг хоногийн дотор ажил гүйцэтгэгчид мэдэгдэнэ.
- 4.10 Захиалагч энэ гэрээний 2.5-д заасны дагуу төлбөрөө төлнө.
- 4.11 Цахилгаан шатны засвар, техник үйлчилгээг гүйцэтгэх үед ажлын чанарт хяналт тавьж, ажлын төгсгөлд лифтээ хүлээн авч байна.

Тав. Ажил гүйцэтгэгчийн эрх, үүрэг

- 5.1 Гүйцэтгэгч нь захиалагч талд сард 1 удаа засвар үйлчилгээний ажлыг энэхүү гэрээний дагуу захиалагчийн хариуцсан цахилгаан шатанд техникийн үзлэг хийх болон засвар техник үйлчилгээний ажлыг хийж гүйцэтгэнэ.
- 5.2 Ажил гүйцэтгэгч техник үйлчилгээгээр цахилгаан шатны эд ангиудыг тоос, тосноос цэвэрлэх, тослогооны байдлыг шалгах, тослогоо хийж, бүх бэхэлгээний болон цахилгаан утасны холболтын боолтуудыг чангалах, цахилгаан утас, контакторуудыг шалгаж, контактуудыг цэвэрлэх, тохиргоо хийгддэг зай хэмжээсүүдийг нормдоо байгаа эсэхийг хэмжиж, шалгаад алдагдсан бол тохируулах ажил гүйцэтгэнэ.
- 5.3 Захиалагч талтай тохиролцон Цахилгаан шатны техник үйлчилгээний график гарган, түүнийг мөрдөн ажиллана. Мөн графикт техник үйлчилгээний хооронд гарсан эвдрэл гэмтлийг засварлана.
- 5.4 Цахилгаан шатны паспорт дээр цахилгаан шатанд хийгдсэн ажил, дараагийн техник үйлчилгээ хийхэд шаардагдах сэлбэг, материал, цахилгаан шат эзэмшигчийн анхаарах зүйлс, цаашид олж бэлтгэн нөөцлөх сэлбэг материалын жагсаалтыг бичиж, гарын үсэг зурж байна.
- 5.5 Эвдрэл гэмтэл гарсан үед түүний шалтгааныг тодорхойлохдоо захиалагчийн төлөөлөгчийг байлцуулах ба тавигдсан сэлбэг, хийгдсэн засвар үйлчилгээг үнэн зөв тодорхойлно.

- 5.6 Цахилгаан шатны ашиглалтын талаар захиалагчид заавар, зөвлөгөө өгнө.
- 5.7 Ажилтнуудаа ажлын хувцас, багаж, түлхүүрээр бүрэн хангаж ажиллана.
- 5.8 Гэрээт ажлыг гүйцэтгэх хугацаанд ажилтандаа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгааг байнга өгч, холбогдох журмыг чанд мөрдөн ажиллах, түүнээс гарах үр дагаврыг хариуцна.
- 5.9 Цахилгаан шатны лифтчин аттестатчилахад оролцох, захиалагчид цахилгаан шаттай харьцдаг субъектүүдийн мөрдөн ажиллах журмыг олж өгөх үүрэгтэй.
- 5.10 Ажил гүйцэтгэх явцад захиалагчид ажлын явцын талаар мэдээлэл өгч ажиллана.
- 5.11 Захиалагч талд гэрээний 7.4.2-т заасан нөхцөл байдал үүссэн, аливаа эрсдэл үүсэж болзошгүй болохыг сануулсаар байтал үйл хайхран гэрээг зөрчин лифтийг ажиллуулснаас аливаа эрсдэл хохирлыг гүйцэтгэгч тал хариуцахгүй.

Зургаа. Гэрээ дүгнэх журам

- 6.1 Талуудын тухайн ажлыг хариуцсан ажилтан нар гэрээний эцсийн үр дүнг гэрээ дүгнэсэн акт үйлдэн дүгнэнэ.
- 6.2 Захиалагч талаас тухайн ажлыг гүйцэтгэх захирал хариуцан ажиллах бөгөөд гэрээг дүгнэнэ.
- 6.3 Гэрээ дүгнэсэн актад хугацаа, ажлын чанар, үр дүнг тусгасан байна.
- 6.4 Гэрээ дүгнэсэн актад талууд гарын үсэг зурж баталгаажуулна.
- 6.5 Гэрээ дүгнэсэн акт нь гэрээний салшгүй хэсэг байна.

Долоо. Талуудын хүлээх хариуцлага

- 7.1 Талууд нь Монгол улсын хууль, тогтоомж, холбогдох дүрэм, журам, энэхүү гэрээг сахин биелүүлж ажиллана.
- 7.2 Цахилгаан шатанд эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд ажил гүйцэтгэгч 24 цагийн дотор ирж засвар, үйлчилгээ хийх ба хэрэв энэ дуудлага зүй бус байвал /лифтчин чадваргүйгээс эсвэл лифтчин байхгүйгээс болж түүний хийх ёстой ажлын шалтгаанаар дуудлага өгөгдсөн/ захиалагч уг дуудлагад 8000 төгрөг гүйцэтгэгчид төлнө.
- 7.3 Гэрээнд оролцогч талууд нь гэрээнд тусгагдсан эрх, үүргээ бүрэн биелүүлж ажиллана.
- 7.4 Дараах тохиолдолд гүйцэтгэгч лифтийг ажиллуулахыг хориглон зогсооно.
 - 7.4.1 Мэргэжлийн лифтчин үгүй бол
 - 7.4.2 Лифтийн техникийн байдалд осол, аваар гарч болзошгүй хэмжээний гэмтэл илэрсэн бол түүнийг засаж хэвийн байдалд оруулах хүртэл
 - 7.4.3 Машины өрөө, хонгил, бүхээгний гэрэлтүүлэг дутуу, хонгил машины тасалгаа +5 хэмээс хүйтэн уур, ус, цанталт үүссэн үед
- 7.5 Энэ гэрээний 7.4.2-д заасан нөхцөл байдал үүссэн, үүсэж болзошгүй тохиолдолд захиалагч тал ажил гүйцэтгэгч талд нэн даруй мэдэгдэнэ. Хэрэв мэдэгдээгүйгээс үүссэн аливаа хариуцлагыг ажил гүйцэтгэгч тал хариуцахгүй болно.

Найм. Гэрээг хугацаанаас өмнө цуцлах үндэслэл

- 8.1 Талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бөгөөд үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоосон боловч үр дүн гараагүй бол нөгөө тал гэрээнээс татгалзах эрхтэй.
- 8.2 Талууд гэрээнд заасны дагуу гэрээг хугацаанаас өмнө цуцлахыг хүсвэл энэ тухай саналаа нөгөө талд ажлын 5-аас доошгүй өдрийн өмнө албан бичгээр мэдэгдэнэ.
- 8.3 Талууд харилцан тохиролцсоноор гэрээг цуцалж болно.
- 8.4 Хуульд заасан бусад үндэслэлээр гэрээг цуцалж болно.

Ес. Маргаан шийдвэрлэх журам

- 9.1 Энэхүү гэрээнд заагаагүй аливаа асуудлыг Монгол улсын хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

- 9.2 Энэхүү гэрээний хэрэгжилтийн явцад талуудын хооронд гарах аливаа асуудлыг албан бичгээр мэдэгдэнэ.
- 9.3 Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар үүссэн маргааныг гэрээний үндсэн нөхцөл, агуулгад нийцүүлж талууд зөвшилцөх замаар шийдвэрлэх ба зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд Монгол улсын хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

Арав. Давагдашгүй хүчин зүйл

- 10.1 Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл болно.
- 10.2 Гэнэтийн буюу давтагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний үйлчлэх хугацааг тухай нөхцөл байдлыг арилгах хүртэл хойшлуулж болно.
- 10.3 Гэрээний үүргийг биелүүлэхэд саад болох нөхцөл байдал үүссэн тухай талууд нэн даруй нэг нэгэндээ бичгээр мэдэгдэнэ.

Арван нэг. Бусад нөхцөл

- 11.1 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох бөгөөд гэрээний хугацаа дуусгавар болсноор гэрээ дуусгавар болно.
- 11.2 Гэрээний аль нэг тал гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд энэ тухай саналаа бичгээр мэдэгдэх ба нөгөө тал уг саналыг хүлээн авснаас хойш ажлын 5-аас доошгүй өдрийн дотор хариу мэдэгдэнэ.
- 11.3 Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд түүнийг бичгээр үйлдэх бөгөөд талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж баталгаажуулснаар уг нэмэлт өөрчлөлт нь хүчин төгөлдөр болно.
- 11.4 Гэрээний нэмэлт өөрчлөлт нь гэрээний салшгүй нэг хэсэг байна.
- 11.5 Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж захиалагч тал 1 хувийг, ажил гүйцэтгэгч тал 1 хувийг тус тус хадгалах ба гэрээний хувь тус бүр хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.
- 11.6 Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Ажил гүйцэтгэгч:

Захиалагч:

“Улаанбаатар лифт” НӨҮГ-ын

“.....” СӨХ-ын
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ДАРГА: /Д.ГАН-ЭРДЭНЭ/

/...../

Хаяг: БЗД 15-р хороо
13-р хороолол 6-р байрны урд талд
Өөрийн байранд
Утас: 70162680
Банкны нэр: Төрийн сан
Дансны дугаар: 100200051073

Хаяг:
Утас:
Байгууллагын РД: